



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/669

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр нь шатаж орон гэргүй болсон иргэн Л.Бат-Эрдэнэд 1,000,000 (Нэг сая) төгрөг, эмчилгээ хийлгэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Д.Мандалд 1,000,000 (Нэг сая) төгрөг, иргэн Ц.Чулуун, Б.Бадарч, Л.Батсайхан нарт тус бүр 300,000 (Гурван зуун мянган) төгрөг нийт 2,900.000 (Хоёр сая есөн зуун мянган) төгрөг, хүйтний эрч нэмэгдэж, томуу, томуу төст өвчин ихэсч байгаатай холбогдуулан Мөрөн сумын алслагдсан Далайн-Элбэрэлт өрхийн Эрүүл мэндийн төвийн дулаантай холбоотой үйл ажиллагааг хэвийн ажиллуулахад шаардлагатай зардалд 8,497.200 төгрөгийг (Найман сая дөрвөн зуун ерин долоон мянга хоёр зуун мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардлын 11,397.200 (Арван нэгэн сая, гурван зуун ерин долоон мянга хоёр зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

